

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2026.04.13

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын 3-р сарын инфляц 3.3%-д хүрч огцом өслөө.
- Газрын тосны ханш одоогийн 100 орчим ам.долларт удаан хадгалагдвал инфляц өндөр хэвээр байна.
- АНУ Ираны боомтуудыг бүслэх шийдвэр гаргалаа.
- JD Vance Ирантай хэлэлцээр хийх гэж уулзсан боловч тодорхой үр дүнд хүрсэнгүй.
- Хятадын үйлдвэрлэгчдийн үнийн индекс хүчтэй өслөө.
- Хятадын зах зээл дээр үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж байна.



S&P 500 индексийн 2026 оны таамаглал

Capital Economics	8,000
Deutsche Bank	8,000
Wells Fargo	7,800
Morgan Stanley	7,800
Goldman Sachs	7,750
RBC	7,750
JPMorgan	7,500
HSBC	7,500
UBS	7,500
Barclays	7,400
Bank of America	7,100
Дундаж	7,645





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2026.04.06-04.12

АНУ-ЫН 3-Р САРЫН ИНФЛЯЦ 3.3%-Д ХҮРЧ ОГЦОМ ӨСЛӨӨ

АНУ-д инфляц дахин нэмэгдэж, эдийн засгийн өсөлт удааширч буйг сүүлийн макро үзүүлэлтүүд харуулж байна. 3-р сард хэрэглээний үнийн индекс (CPI) жилийн дүнгээр 3.3% болж, 2-р сарын 2.4%-аас огцом өссөн бөгөөд энэ нь 2024 оны 5-р сараас хойших хамгийн өндөр түвшин юм. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь шатахууны үнэ огцом нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд нийт өсөлтийн ихэнхийг бүрдүүлжээ.

Нөгөө талаас эдийн засгийн өсөлт саарч, 2025 оны 4-р улирлын ДНБ-ийн өсөлтийг 0.7%-аас 0.5% болгон бууруулан шинэчилсэн байна. Энэ нь хөрөнгө оруулалт буурсантай холбоотой гэж тайлбарлагджээ.

Газрын тосны ханш болон инфляцын хамаарал



Газрын тосны ханш одоогийн 100 орчим ам.доллар дээр удаан хугацаанд тогтвол АНУ-ын инфляц 3.5% түвшинд удаан хадгалагдах магадлал өндөр хэвээр байна.

АНУ ИРАНЫ БООМТУУДЫГ БҮСЛЭХ ШИЙДВЭР ГАРГАЛАА

Амралтын өдрүүдэд Пакистан улсад болсон АНУ-Ираны 21 цаг үргэлжилсэн хэлэлцээ тодорхой үр дүнд хүрэлгүй дуусч, АНУ-ын төлөөлөгч JD Vance гэрээ хэлцэлгүй буцсан байна. Үүний дараа АНУ-ын Ерөнхийлөгч Donald Trump-ын тушаалаар АНУ-ын тэнгисийн цэрэг Ираны боомтуудыг бүслэх ажиллагааг эхлүүлэхээр болсон.

АНУ-ын зүгээс Ираны боомт руу орж, гарч буй бүх хөлөг онгоцыг хянах бөгөөд мөн Ормузын хоолойгоор дамжин өнгөрөхдөө Иранд төлбөр төлсөн хөлөг онгоцуудыг саатуулах арга хэмжээ авах юм.

АНУ Иранаас цөмийн зэвсэг хөгжүүлэхгүй гэсэн тодорхой амлалт шаардаж байгаа бол Ираны тал АНУ-д итгэх итгэлгүй байгаагаа илэрхийлж, байр суурь зөрүүтэй хэвээр байна. Мөн нөхцөл байдал цаашид улам хурцдаж, АНУ Иранд цохилт өгөх боломжийг ч судалж байгаа нь эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2026.04.06–04.12

Хятадын эдийн засагт хоёр чухал өөрчлөлт гарлаа. Үүнд: үйлдвэрлэлийн үнэ өсөж эхэлсэн бол хөрөнгийн зах зээлийн зохицуулалт илүү чангарч байна.

Хятадын үйлдвэрлэгчдийн үнэ (PPI) 3 гаруй жилийн дараа анх удаа өсөж, 3-р сард 0.5%-иар нэмэгдсэн байна. Энэ өсөлт нь АНУ болон Ираны зөрчлөөс шалтгаалсан түүхий эд, эрчим хүчний үнийн өсөлт эдийн засагт нөлөөлж эхэлснийг харуулж байна. Өмнө нь 41 сарын турш үнэ буурч байсан нь өрсөлдөөн ширүүсч, компаниуд үнээ бууруулж байсантай холбоотой байв. Гэхдээ энэ өсөлт нь эрэлт сайжирснаас биш, харин зардал нэмэгдсэнээс үүдэлтэй. Харин хэрэглээний инфляц (CPI) эсрэгээрээ 1% болж буурсан нь Цагаан сарын дараах улирлын эрэлт сул байсантай холбоотой юм.

Нөгөө талаар, Хятадын Үнэт цаасны зохицуулах хороо зах зээлд илүү хатуу журам хэрэгжүүлж эхэллээ. Шинэ дүрмээр компанийн 5%-иас дээш хувь эзэмшигчид, удирдлагууд болон тэдний гэр бүлийнхэн нэг хувьцааг 6 сарын дотор худалдаж, зарж арилжаалахыг хориглож байна.

ХЯТАД УЛСЫН ТАЙВАНИЙН ТАЛААРХ АРГА ХЭМЖЭЭ

Хятад улс Тайваны сөрөг хүчний намын дарга Cheng Li-wun Бээжинд айлчилсны дараа Тайванд чиглэсэн 10 төрлийн шинэ хөнгөлөлт, урамшууллын бодлого зарлалаа. Энэ хүрээнд аялал жуулчлалын хязгаарлалтыг сулруулах, нислэгийг сэргээх, хүнс болон загасны бүтээгдэхүүний шалгалтыг хялбарчлах зэрэг арга хэмжээ багтаж байна.

Мөн Бээжин Тайваны КМТ намтай тогтмол харилцах механизм байгуулах санал гаргасан нь улс төрийн харилцааг бэхжүүлэх оролдлого гэж үзэгдэж байна. Гэвч эдгээр алхмууд нь “Тайвань тусгаар тогтнохыг эсэргүүцэх” улс төрийн нөхцөлтэй холбоотой гэдгийг онцолсон байна.

Hang Seng индекс



